



/тусгай дугаар/

1987-1991 ОНД ЦЭРГИЙН НЭГДСЭН ДЭЭД СУРГУУЛИЙГ ТӨГСӨГЧДИЙН 30 ЖИЛИЙН ОЙН БАЯРЫН МЭНД ХҮРГЭЭ!

НАСААРАА БИД НЭГ АНГИЙНХАН



БИДНИЙ СОНСОГЧ НАС ГЭРЭЛ ЗУРГИЙН ХАЛЬСНАА



Монгол Улсын боловсролын ууган байгууллагуудын нэг Үндэсний Батлан Хамгаалахын Их Сургуулийн 100 жилийн түүхэн цаг хугацаанд 1987 онд Ерөнхий цэргийн команд-явган цэргийн байлдааны машины ашиглалтын инженер, Артиллерийн команд-артиллерийн зэвсэглэлийн ашиглалтын инженер, Улс төрийн ажилтан, Радио болон утсан холбооны инженер, Авто инженер, Ар талын инженер, Цэргийн эдийн засагч, Хуягт танк ашиглалтын инженер гэсэн долоон мэргэжлээр дээд боловсрол эзэмшихээр 200-аад сонсогч өөрийн чин хүсэл сонирхол, итгэл үнэмшлээр тус сургуульд элсэн суралцаад 1991 онд төгссөнөөс хойш тэд 30 жилийг ардаа үздэг байна.

Түүхт 30 жилийн хугацаанд эдгээр төгсөгчид Монгол эх орныхоо тусгаар тогтнол, эрх чөлөөт ард түмнийхээ энх амгаланг батлан хамгаалж, аюулгүй байдлыг бэхжүүлж, дэлхийн энхийг дэмжих ажиллагаа, улс орны бүтээн байгуулалт, хөгжил дэвшлийн их үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулсаар ирсэн юм. Мөн энэ хугацаанд тэдний дундаас бригадын

генерал-2, хурандаа-13 төрөн гарсны зэрэгцээ төр засаг, хувийн хэвшлийн байгууллагад манлайлан ажиллаж, бидний бахархал болсон. Тухайлбал, ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын дарга бригадын генерал С.Дашзэвэг, ОБЕГ-ын дэд дарга бригадын генерал Б.Ууганбаяр, Монгол Улсаас Бүгд Найрамдах Казахстан Улсад суугаа Элчин сайдын яамны батлан хамгаалахын атташе хурандаа Б.Дамба, Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн захирагч хурандаа Д.Жигжидсүрэн, ЦДБЭЧ-ын дарга хурандаа Г.Золзаяа, Зэвсэгт хүчний 345 дугаар нэгтгэлийн штабын дарга хурандаа Н.Алтангэрэл, ҮБХИС-ийн Санхүүгийн хэлтсийн дарга хурандаа Х.Батсүх, Артиллер, Зэвсгийн тэнхимийн дарга хурандаа Ц.Цэрэнбат, Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтсийн дарга хурандаа Г.Баатар, БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газрын дарга Ч.Батсансар, Өмнөд бүсийн холбооны газрын захирал, Монгол Улсын зөвлөх инженер

Ц.Баярсайхан, Өвөрхангай аймгийн Засаг даргын орлогч агсан, ерөнхий аудитор О.Батжаргал /ЕЦ/, Мэдээлэл, холбооны Сүлжээ ТӨХК-ийн ерөнхий захирал Л.Одон, Хөшигийн хөндийн Олон улсын нисэх буудлын аюулгүй ажиллагаа, хамгаалалтын албаны дарга Н.Төмөрбаатар, Төрийн өмчит "Эрдэнэс Монгол" ХК-ийн МШЗА-ны дарга С.Алтанхуяг, Мэдээлэл, холбооны Сүлжээ ТӨХК-ийн Завхан аймаг дахь салбарын ерөнхий инженер Ц.Эрдэнэсайхан, MCS ХХК-ийн албаны дарга А.Баясгалан нарыг дурдаж болох юм.

Ийм л бахархам хүмүүсийг эгнээнээсээ төрүүлсэн ЦНДС-ийн 1991 оны 61 дэх төгсөгчид өнөөдөр түүхт 30 жилийн ойн хүндэтгэлийн арга хэмжээгээ ёслол төгөлдөр тэмдэглэж байна.

Цэрэг хүний оройн дээд шүтээн бүх цэргийн их хар сүлднээ хүндэтгэн мөргөж, ҮБХИС-ийн байлдааны тугандаа хүндэтгэл үзүүлснээр тэдний өнөөдрийн үндсэн арга хэмжээ эхэлж, сонсогч ахуй насаа дурсан 30 жилий өмнөх өдрүүдээр аялах буй за.

КУРСИЙН БАХАРХАЛ АЛТАН МӨРДЭСТ ГЕНЕРАЛУУД

Хагас сайн болгонд зэвсэг хэрэгслээ үүрээд маршид гүйж, хавар намрын цагтаа тариа, ногооны талбайд хөдөлмөрлөж, казармын шалыг зүлгэж, ороо жимбийтэл хураан эмх цэгцэд суралцаж, курсийн ах нараасаа үлгэр авч, хувцсаа тэвхийтэл өмсөж, хромоо гялалзтал тосолж, хамтдаа суралцангаа амьдарч, хариуцлагаа хамтдаа үүрэлцэж явсан ЦНДС-ийн 1991 оны 61 дэх төгсөгчдийн дундаас алтан мөрдөст генерал хосоороо төрсөн нь бригадын генерал С.Дашзэвэг, Б.Ууганбаяр нар билээ.

Багаасаа "Цэргийн хүн болно" гэсэн дэврүүн мөрөөдлөөр жигүүрлэн байж энэхүү сургуулийн Ерөнхий цэргийн Б курсийн сонсогч болж байсан С.Дашзэвэг



Өнөөдөр ЗХЖШ-ын Ажиллагааны Удирдлагын Газрын даргын хариуцлагатай албыг хашиж, орчин цагийн

Монгол Улсын Зэвсэгт хүчний өнгө төрх, бодлого зорилтыг тодорхойлолцож явна. Харин Ар талын инженер, эдийн засгийн курсийн сонсогч Б.Ууганбаяр сургуулиа төгсөөд Улсын иргэний хамгаалалтын албанд шилжээд, өнөөдөр Монгол Улсын онцгой байдлын салбарт 26 жил ажиллахдаа Онцгой байдлын ерөнхий газрын дэд даргын албыг хашиж, ажил үйлс, амьдрал ахуй өөдрөг яваагаа төрөлх сургуулийн минь ач хэмээн бахархан боддог.

Сонсогч ахуйн сурсан эрдэм мэдлэг ажил, амьдралын үндэс болж, казармаас эхэлсэн цэргийн андуудын нөхөрлөл насан туршийн нандин холбоо болох нь энэ буюу.
Д. ГҮНЖИЛМАА

С.ДАШЭВЭГ: СОНСОГЧИЙН ОН ЖИЛҮҮД БОЛ БИДНИЙ АМЬДРАЛЫН ХАМГИЙН САЙХАН, ХЭЗЭЭ Ч МАРТАГДАХГҮЙ ДУРСАМЖ ДҮҮРЭН ОН ЖИЛҮҮД

ЗХЖШ-ын Ажиллагааны Удирдлагын Газрын дарга, бригадын генерал С.ДАШЭВЭГИЙН 1987-1991 онд Цэргийн нэгдсэн дээд сургуулийн төгсөгчдийн 30 жилийн ойн баярын хурал дээр тавьса " ЦЭРГИЙН НЭГДСЭН ДЭЭД СУРГУУЛИЙГ ТӨГССӨНИЙ 30 ЖИЛИЙН ТҮҮХЭН ЗАМНАЛ" илтгэлийг бүрэн эхээр хүргэж байна.



болсон түүхтэй.

Сонсогчийн он жилүүд бол бидний амьдралын хамгийн сайхан, хэзээ ч мартагдахгүй дурсамж дүүрэн он жилүүд байсан.

Шалаа зүлгэж, байраа цэвэрлэж, цэргийн казармд ороо нийлүүлэн зэрэгцэн унтаж, оюутны ширээнд тохой нийлүүлэн сууж, байгаль цаг уурын ямар ч үед цэргийн хэргийн болон байгаль, нийгмийн ухааны мэдлэг олж авах гэж шамдан суралцаж, цагийн манаанд ээлжлэн зогсож, даарч бээрэхээ мартан, тэсвэр хатуужлыг даван туулсан.

Цэргийн анхан шатны бэлтгэл, Намрын ургац хураалт, хаврын коммунист суботник гээд тухайн үеийн нийгмийн ард иргэд, олон нийтийг хамарсан компани ажилд дайчлагдан оролцож, жил бүрийн улсын баярын наадмаар парадд жигдрэн жагсаж, хөл нийлүүлэн цог хийморьтой алхаж 2-оос 3 сарын бэлтгэл хийж, мэргэжлийн үндэс сургалтаас гадна хэргийн сургалт дадлагаар тактик, галын бэлтгэл, байр зүйн хичээлүүдийг, үндсэн төрлийн байлдааныг төлөвлөх удирдах, төрөл бүрийн зэвсгээр мэргэн буудах, байлдааны техникүүдийг жолоодох, их бууны буудлага хийх, холбооны техник хэрэгсэл дээр ажиллах мэдлэг чадварыг бид бүхэн олж авчгаасан.

Мөн Цэргийн хэргийн

гарнизонууд руу томилогдон одоо, ажил амьдралынхаа анхны гарааг эхэлж байлаа.

Бидний сурч байсан он жилүүдэд ЗХУ-ын коммунист систем бүхэлдээ задран унаж, Монгол эх оронд маань ардчилсан хувьсгалын их сэвэлзээ нийгмийн тогтолцоог өөрчилсөн, улс орон маань ардчилсан нийгэмд шилжсэн үе төдийгүй, батлан хамгаалах салбарт ч Монгол Улсын хэмжээнд социалист нийгмээс иргэний ардчилсан нийгэмд шилжих шилжилтийн үе эхэлж, Мэргэжлийн кафедрт сургалт, цэргийн албыг нэгтгэн түүний бүтцэд багш нараас гадна рот, батареины удирдлагыг оруулсан түүхэн цаг үе байлаа.

Мөн олон жил ам дамжин яригдаж байсан Сонсогч нар гадуураас суралцах үеийн анхны эхлэл тавигдсан сайхан үе байлаа.

Ажил амьдралын амаргүй замыг туулж, Монгол улсын батлан хамгаалах салбарын одоо болон ирээдүйн бодлого, зорилтыг тодорхойлж яваа мөрдөс нэгт дайчин нөхдийн дундаас Ирак, Афганистан, Серра лион, Өмнөд Судан зэрэг улс оронд энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэж Монгол цэрэг-Дэлхий цэрэг болоход чухал хувь нэмэр оруулсан.

1991 онд ЦНДС-ийн 61 дэх төгсөгчдийн дотроос МУ-ын бригадын генерал-2 С.Дашэвэг /ЕЦ/, Б.Ууганбаяр /



Эрхэм хүндэт ЦНДС-ийн 1991 оны төгсөгч найзууд аа

Эрхэм хүндэт кафедрны дарга, эрдэмтэн багш нараа

Эрхэм хүндэт рот, батарей, курсийн захирагч нараа

Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэж, Цэргийн нэгдсэн дээд сургуулийг төгссөний 30 жилийн ойн баярын дайчин цогтой халуун мэндийг дэвшүүлж, ажилд чинь амжилт, амьдралд чинь аз жаргал, эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөж, төгсөлтийн баярын арга хэмжээнд зориулсан баярын хурлын ажиллагааг нээснийг мэдэгдье.

Эдүгээгээс 30 гаруй жилийн тэртээ Сүхбаатарын болон байлдааны гавьяаны улаан тугийн одонт жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит ЦНДС-д элсэн суралцахаар 1987



оны зуны сар буюу 07 дугаар сард Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хотоос болон 18 аймгаас өөрийн чин хүсэл сонирхол, зорилгодоо хөтөлгөдөн тухайн үеийн элсэлтийн шалгалтад тэнцэж, Цэргийн нэгдсэн дээд сургуулийн Ерөнхий цэргийн команд-ЯЦБМ-ын ашиглалтын инженер, Артиллерийн команд-Артиллерийн зэвсэглэлийн ашиглалтын инженер, Улс төрийн ажилтан, Радио болон утсан холбооны инженер, Авто инженер, Ар талын инженер, цэргийн эдийн засагч, Хуягт танк ашиглалтын инженер гэсэн 7-н дээд боловсролтой цэргийн мэргэжил эзэмшихээр 8 курст 190 гаруй сонсогч элсэн орж суралцаж "Будилж явсан багийн зангаа орхиж, Буу үүрсэн сонсогч болж, Түмэн олноо амгалан байлгаж гэж, Төр, улсдаа тангараг өргөсөн Насан туршийн андууд"

болон Салааны захирагчийн дадлагыг 1989 оны 12 дугаар сард тухайн үеийн хээрийн академи гэгдэх Их говийн гарнизон буюу Дорноговь аймгийн Зүүнбаянд хийцгээсэн бол өөрсдийн мэргэжлийн дадлагыг 1991 оны 2-3 дугаар саруудад нийслэл Улаанбаатар, Төв аймгийн цэргийн хүрээний ангиудад тус тус хийдэг байсан үеэ дурсан санахад сайхан байна.

Хүн цэнгийн дэгдээхэй өд сөдөө ургахаар гурван далайг гаталж, хулан тахийн унага нас бие гүйцэхээрээ гурван говийг туулдаг лугаа адил бид бүхэн төрөлх ЦНДС-иа 150 сонсогч төгсөөд БХ-ын сайдын тушаалаар дэслэгч цол хүртээд эх орны дөрвөн зүг найман зовхит ЕЦ, Артиллерийн, Холбоо, Улс төрийн курс нийлээд 90-ээд дэслэгч Зүүнбаянд бусад нь Өмнөговь, Ховд, Эрдэнэт зэрэг алслагдсан

Ар тал/, хурандаа-13 хурандаа Д.Жигжидсүрэн /ЕЦ/, Б.Дамба/ ЕЦ/, И.Батсайхан /Артиллерий/, Д.Амарсанаа /Танк, Г.Золзаяа / Улс төр/, Х.Батсүх /Ар тал/, Н.Алтангэрэл /Холбоо/, Г.Баатар /Ар тал/, Р.Болдбаатар /ЕЦ/, Б.Болдбаатар /Артиллерий/, М.Ариунболд /Авто/, Ц.Цэрэнбат /Артиллерий/, Ш.Мэндсайхан /ЕЦ/, Цэргийн ухааны доктор /Ph.D.-1 хурандаа И.Батсайхан, Техникийн доктор /Ph.D.-1 цагдаагийн хурандаа М. Ариунболд нараас гадна, өнөөдрийн байдлаар Төр засаг, хувийн хэвшлийн байгууллагуудад манлайлан ажиллаж байгаа бидний бахархал болсон ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын дарга бригадын генерал С.Дашэвэг, ОБЕГ-ын дэд дарга бригадын генерал Б.Ууганбаяр, Монгол Улсаас Бүгд Найрамдах Казахстанд суугаа Элчин сайдын

таатай байна.

Цаашид бүхэн төрөлх сургуулиараа байнга бахархаж, үе үеийн удирдлага, эрдэмтэн багш, курс салбарын захирагч нарын зааж сургасан сургамж, ажил дадлага туршлагыг ажил, амьдралдаа хэрэгжүүлэн ажиллаж, сургууль, хамт олон та бүгдтэйгээ байнгын холбоотой байхыг андгайлж байна

Энэхүү ЦНДС-ийн төгссөний 30 жилийн арга хэмжээ удирдан зохион байгуулан, явуулсан, оролцсон бүх хүмүүст, ойлг тэмдэглэн өнгөрүүлэх комиссын гишүүдийн өмнөөс болон хувиас гүн талархал илэрхийлж байна.

Мөрдэс зүүж Мөр зэрэгцэн жагсаж явсан Онжавууд бидний андын нөхөрлөл Алдар гавьяа үеийн үед мандан бадартугай.

Дарга, ерөнхий редактор, хурандаа САНЖМЯТАВЫН ТӨМӨРХУЯГ

ЦАХИМ ХАЯГ
Батлан хамгаалах яам
Зэвсэгт хүчний Жанжин штаб

ЦАХИМ ХУУДАС
"Соёмбо" сонин
"Дуулга" студи

* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.
* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.
* Тус сонин мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс: 10018
Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn
Утас: 70001029, 3412 (дотуур)